



АГУУЛГА

1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн
2. Нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын хүрээнд
 - *Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тэтгэвэр тэтгэмжийн чиглэлээр*
 - *Нэг цэг, цахим үйлчилгээний ажлын чиглэлээр*
3. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, төсөв, төсвийн гүйцэтгэл
 - *Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт*
 - *Иргэдийг нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх*
 - *Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлт, санхүүжилт*
 - *Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ гаргах ажлын чиглэлээр*
 - *Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр*
4. Төрийн үйлчилгээг хөгжүүлэх, цахим үйлчилгээ
 - *Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх*
 - *Архивын үйл ажиллагааны талаар*
5. Хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шалгалт, дотоод аудитын шалгалт хийх үйл ажиллагаа
 - *Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах*
6. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах чиглэлээр
7. Мэдээллийн технологи, Сургалт, сурталчилгааны чиглэлээр
8. Бусад буюу шинэлэг ажлын хүрээнд



Тус газар нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлсэн, даатгуулагчийн эрхийг дээдэлсэн, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн хэрэгцээг мэргэжлийн түвшинд хөнгөн шуурхай байдлыг хангаж, нийгмийн даатгалын асуудлаар бүх талын дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгох, ажил олгогч, даатгуулагч иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, 2024 оныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/52 дугаар тушаалаар тус газар нь 60 орон тоогоор батлагдсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар дараах зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнд:






Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн багц хууль, шинэ бүтэц орон тооны дагуу Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/08 тушаалаар газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж тус газрын ажилтан, албан хаагчдын хурлаар танилцуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албаны ёс зүйг иргэдэд үзүүлэх, төрийн ажил үйлчилгээг ил тод, шударга, шуурхай болгох, цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Холбогдох хууль тогтоомж, газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу албан хаагчдын ажлын цагийн бүртгэл, хяналт, ажлын цаг ашиглалтын тайлан мэдээг “Газрын даргын зөвлөлийн хурал”-д танилцуулж, үр дүнг тооцон ажиллаж байна. Тус газрын Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын төлөвлөгөө, тухайн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулан, газрын даргаар батлуулж, төлөвлөгөө нь албан хаагчийн гүйцэтгэлийн зорилт, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт гэсэн хоёр хэсгээс бүрдэж хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх үүргийг дэлгэрэнгүй тусган ажиллалаа.

ХОЁР: НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- **Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн чиглэлээр**


Тус газар нь 2024 оны байдлаар сар бүр дунджаар 23797 тэтгэвэр авагчдын 20,1 тэрбум төгрөгийн тэтгэврийн тооцоог хийж, олгосон ба тэтгэврийн олголтыг долоо хоногт 4-5 удаа тухай бүр хийж тэтгэвэр авагчдад чирэгдэл, хүндрэл учруулахгүйгээр хурдан шуурхай үйлчлэн ажилласан.

2024 оны тэтгэвэр олголтыг сараар ангилан харуулбал






Сүүлийн 3 жилийн тэтгэвэр авагчдын тоон үзүүлэлт



Сүүлийн 3 жилд олгосон тэтгэвэр /тэрбум.төг/



Тэтгэвэр олголтын тайланг сар бүр хороо, арилжааны банкны салбараар нэгтгэн гаргаж, тэтгэврийн даатгалын сангийн зарлагын харилцахтай тохируулан зарлагын нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор сар бүр баталгаажуулан олгож ажиллалаа. Тэтгэврийн олголтыг сард 5 удаа банкуудад файлаар явуулж, хяналт тавин ажиллаж байна.

Шинэ систем нэвтрүүлж байгаатай холбоотой системээс илгээж болохгүй байгаа олголтуудыг EXCEL файлаар жагсаалт бэлтгэн банкуудад хүргүүлж байна.

Шүүхийн шийдвэрээр тэтгэврээс суутган төлдөг тэтгэврийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанд хугацаанд нь шилжүүлэн ажилласан.



Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиглэлийн дагуу Сикос шинэ системд бүртгэгдсэн тэтгэврийн олголт болон эксел файлаар олгосон жагсаалтыг тулган шалгах ажил хийсэн.

Тайлант хугацааны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тэтгэмжийн даатгалын сангаас 8 төрлийн тэтгэмжид 15878 даатгуулагчдад 27,8 тэрбум төгрөг олгосон байна.

Үүнийг тэтгэмжийн төрлөөр нь ангилан харуулбал:

№	Үзүүлэлт	2024 оны байдлаар	
		Тоо	Мөнгөн дүн /төг/
1.	Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж	10465	4,555,438.24
2.	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	2223	9,719,188.27
3.	Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж	644	1,280,000.00
Дүн		13332	15554626.51
4.	Ажилгүйдлийн тэтгэмж	2224	10,295,638.18
Дүн		2224	10,295,638.18
5.	ҮОМШӨ ХЧТА тэтгэвэр	143	1,418,747.90
6.	ҮОМШӨ тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15	123,347.36
7.	ҮОМШӨ ХЧТА	151	457,436.75
8.	ҮОМШӨ нөхөн сэргээх зардал	0	0
9.	ҮОМШӨ сувиллын зардал	13	2,076.11
Дүн		322	2,001,608.12
10.	Нийт дүн	15878	27,851,872.81

Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн чиглэлээр

Тус газрын шинэчлэгдэн батлагдсан бүтэц, орон тооны дагуу Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэст нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг шинээр байгуулагдан 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ, мэдээ, мэдээлэл, зөвлөгөө үзүүлэх чиглэлээр ажиллаж эхлээд байна.



Мөн түүнчлэн ажил олгогч, иргэд даатгуулагчдад төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой “Хурдан” цэгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэн ажиллуулж эхэлснээр 958 иргэд, даатгуулагчдад үйлчилгээ үзүүлснээс 949 лавлагаа гарган төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх боломжийг бүрдүүлж ажилласан. (График 1)

Ингэснээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “20 минутын хот” буюу иргэд оршин суугаа бүсдээ төрийн үйлчилгээг 20 минутад авдаг байх стандартад нийцэж байгаа юм.



“Хурдан” цэгээс ажил олгогч, иргэд, даатгуулагч Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, Улсын бүртгэлийн үйлчилгээ, Иргэний үнэмлэх дахин авах, эд хөрөнгөтэй эсэх лавлагаа, эмнэлэгт цаг захиалах, Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, татварын тайлангаа тушаасан эсэх тухай лавлагаа, татварын өрийн үлдэгдлийн лавлагаа хуулийн этгээдийн татан буугдсан эсэх лавлагаа, газар эзэмших эрхийн лавлагаа төлөх зэрэг үйлчилгээнээс гадна Чингис хаан музейд тасалбар захиалах, Жимобайл, Юнител, Скайтел зэрэг төрийн 43 байгууллагын 478 гаруй лавлагаа, тодорхойлолт, мэдээллүүдийг нэг дороос авах боломжийг бүрдүүлснээр бусад аймаг, дүүргүүдээс ялгарах онцлох ажлуудын нэг болсон.

(График 1)



Нэг цэг, цахим мэдээллийн тасгийн ажилтан, албан хаагчид нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын холбогдолтой хууль, эрх зүйн зөвлөгөө туслалцааг үзүүлэх, даатгуулагчийн вэб программ, гэрэгэ систем, И-баримт, “И-Монголиа” болон “Нийгмийн даатгал” аппликейшнуудыг суурилуулах, ашиглах даатгуулагчид үнэ төлбөргүй нийгмийн даатгалын холбогдолтой мэдээлэл авах тухай болон эрүүл мэнд болон сайн дурын даатгалын төлбөрийг хялбараар аппликейшн ашиглан төлж болохуйц бүхий л зөвлөгөө мэдээллийг өгөн ажиллаж байна.

Мөн тухайн тасаг нь шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдэд зөвлөгөө өгөх, материал хүлээн авах, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг олгох, тодорхойлолт олгох, тэтгэврийн хувийн хэрэг хариуцан баяжуулалт хийх зэрэг ажлуудыг хийж байна.

ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус газар нь 2024 оны тодотгосон төсвөөр нийгмийн даатгалын санд 697,7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 137,9 тэрбум төгрөг, нийт 835,6 тэрбум төгрөг хуримтлуулахаас 642,1 тэрбум төгрөгийг хуримтлуулж, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 193,9 тэрбум төгрөгийг хуримтлуулан сангийн орлогийн төлөвлөгөөг 100.2 хувиар-иар биелүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.


2024 онд нийгмийн даатгалын мэдээллийн баазаас Sicos программд 10664 байгууллагын мэдээлэл хөрвөгдөн орж ирсэн бөгөөд аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл төлөлтийн тайлан илгээхэд системд нэвтрэх эрх, тайлан илгээх заавар,



тайлан илгээхтэй холбоотой гарсан алдаа, системийн шинэчлэлийн талаарх мэдээллийг тухай бүр бүртгэн, мэдээллээр ханган ажиллаж байна.

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр шинээр 793 аж ахуй нэгж байгууллагын 5521 албан журмын даатгуулагч, сайн дурын 1932 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 263, малчин 6, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл /эцэг/ 451 даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулан ажилласан байна.

№	Даатгуулагчдын төрөл	2023 он	2024 он	Гүйцэтгэл
1	Аж ахуйн нэгж байгууллагын тоо	6889	7682	111.5%
2	Даатгуулагчийн тоо	172508	178029	103.2%
3	Сайн дурын даатгуулагч	1541	1932	125.4%
4	0-3 насны хүүхдээ асарч байгаа эх	293	263	89.8%
5	Малчин	3	6	200%
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл /эцэг/	0	451	100%



Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 38 барилга, оффист үйл ажиллагаа явуулж буй 1057 аж ахуй нэгжид нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах бүртгэлгүй ажил олгогч байгууллагыг илрүүлэх, хамруулах ажлыг зохион байгуулж тэмдэглэл үйлдэн 812 аж ахуйн нэгж байгууллагыг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын фэйсбүүк пэйж хуудсыг дагуулж, 473 байгууллагын 2849 албан журмын даатгуулагч шинээр хамруулан ажилласан.

Дүүргийн Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 158 тоот “Ажил олгогчийн жагсаалтыг ирүүлэх тухай” албан бичгээр гаргасан хүсэлтийн дагуу нийт 24647 аж ахуйн нэгжийн жагсаалт ирүүлснээс 10364 байгууллага нь Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газарт бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэлгүй 568 байгууллагатай утсаар холбогдсоноос 21 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлсэн.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Бэлх зах, 100 айл худалдааны төв, Саруул зах, Go to market, Бүрд худалдааны төвүүдээр 270 иргэнд явуулын үйлчилгээ үзүүлж 25 даатгуулагчийн сайн дурын даатгалд шинээр хамруулсан.



Сайн дурын даатгал, Аж ахуй нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт сэдвийн хүрээнд газрын пэйж хуудсаар дамжуулан лайв хийж ажилласан бөгөөд дээрх лайв видео нь нийт 16,600 хандалт авсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 67,5 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагатай гарч үүнээс урсгал авлага 28,5 тэрбум, 91-270 хоногтой 48,6 тэрбум, хуримтлагдсан авлага 39,2 тэрбум төгрөг байна. 2024 оны 12 сарын 1-ний өдрийн байдлаар 87,8 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагатай бөгөөд хүлээж буй гүйцэтгэлээр тайлант хугацаандаа багтааж шимтгэлийн авлагыг 30 хувиар бууруулж ажиллана.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг үүссэн хугацаагаар нь ангилж судалгааг гаргахад 1458 харилцагч байгууллагын дансыг хааж, 41 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 113 байгууллагатай шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулж, 4 аж ахуй нэгжийг шүүхэд шилжүүлж, 70 аж ахуй нэгж байгууллагын хаягын тодорхойлолтыг гаргуулж эрэн сурвалжлуулах шүүхийн шийдвэр гаргуулахаар баримт бүрдүүлэн ажилласан.



ҮЗҮҮЛЭЛТ		2024 онд НДШ-н авлага барагдуулах журмын дагуу авсан арга хэмжээ			
		ААН	Өрийн хэмжээ	ААН	Барагдуулсан
НДШ-н авлага бууруулах-аар авсан арга хэмжээ	Утсаар ярьсан	2041	6261,6	2041	4821,3
	Уулзалт хийсэн	713	13050,3	113	10080,4
	Харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан	1458	42889,5	316	5845,4
	Улсын байцаагчийн албан шаардлага өгсөн	41	12281,3	11	558,7
	Өр барагдуулах гэрээ байгуулсан	113	10080,4	108	3535,3
	Шүүхэд шилжүүлсэн	4	6016,3	2	216,3
	Эрэн сурвалжлуулах шүүхийн шийдвэр гаргуулсан	158	1124,1	13	189,0



Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлт, санхүүжилт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны А/170 дугаартай “Тушаалд өөрчлөлт оруулах” тушаалын дагуу төв, орон нутгийн Нийгмийн даатгалын ерөнхий газарт долоо хоног, сар бүрийн эцэст орлогын хуваарилалт төвлөрүүлэлтийн хийн 2024 оны 01 дүгээр сараас эхлэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын даргын 05/2405 тоот албан бичгийн дагуу өдөр тутмын үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн дансанд төвлөрүүлж 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу банкууд өдөр бүрийн төвлөрсөн харилцах дансны үлдэгдлийг автоматаар төвлөрүүлж байна.



Харин төрийн сангийн төвлөрсөн харилцах дансны орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв төрийн сангийн дансанд тухай бүр цахимаар шилжүүлэн ажиллаж байна.

Мөн 2024 оны “Арилжааны банкттай хамтран ажиллах тухай” гэрээний дагуу төвлөрсөн сангийн хуваарилалалт, торгуулийн орлого, хүүгийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт нэгдсэн журмаар хийж байгаа болно.

Нийгмийн даатгалын сангийн жилийн эцсийн байдлаар 268,9 тэрбум төгрөгийн батлагдсан төсвийн хуваариас 268,0 тэрбум төгрөгийг зарцуулан 0,9 тэрбум төгрөгийг хэмнэн зарцуулахаар төлөвлөн ажилласан байна. Үүнд сан тус бүрээр зарцуулалтыг тооцоолоход:

1.Тэтгэврийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэврийн үндсэн олголтыг гэрээний дагуу сар бүрийн 01-ний өдөр харилцагч банкуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн цахимаар хүргүүлэх шинэ системийн хөгжүүлэлтээс шалтгаалж мэдээллийн санд ороогүй тэтгэврийн олголтыг нэмэлтээр жагсаалт бэлтгэн сард 4-5 удаа харилцагч банкуудад цахимаар илгээн нийтдээ тэтгэврийн санд 241,8 тэрбум төгрөг төсвийн хуваариас 241,3 тэрбум төгрөг зарцуулж 0,5 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн.

2.Тэтгэмжийн даатгалын сангаас ажил олгогч даатгуулагчдын ХЧТА болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийн олголтыг гүйлгээний жагсаалтаар 7 хоногт 3-5 удаа гүйлгээ хийн тэтгэмжийн даатгалын санд 15,9 тэрбум төгрөгийг төсвийн хуваариас 15,5 тэрбум төгрөг зарцуулан 0,4 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн.

3.Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмжийг сарын 7 хоног бүр 1 удаа тоохон шилжүүлж 9,1 тэрбум төгрөгийн төсвийн хуваариас 10,3 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулсан ба төсөв хэтэрсэн асуудлаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт 3 удаа тодотгол хүссэн судалгааг хүргүүлсэн.

4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах даатгалын сангаас холбогдох тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд зардлыг шилжүүлсэн ба 2,0 тэрбум төгрөгийн зардлаас төсвийн хуваарьт багтаан зарцуулсан ба тус газарт тайлан ирүүлдэг “Мон роуд ХХК” –ийн 43 ажилчид ээлж солилцох үеэр осолд орсны улмаас ҮОМШӨ даатгалын сангийн ХЧТА-ын зардал төсвийн хуваариас хэтэрсэн тул тодотгол хийлгүүлсэн.

Сангийн зарцуулалт санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу тухай бүр хүргүүлэн тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд олгож байна.

- Тэтгэврийн санд 241,8 тэрбум төгрөг
- Тэтгэмжийн санд 15,9 тэрбум төгрөг
- ҮОМШӨ санд 2,0 тэрбум төгрөг
- Ажилгүйдлийн санд 9,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Үйл ажиллагааны санхүүжилт, зарцуулалт



Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь тайлант хугацаанд тодотгосон 2551,8 сая төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн сахилга батыг ханган, үйл ажиллагааны зардлыг хэтрүүлэлгүй, эдийн засгийн ангилал, зориулалт, хөтөлбөр арга



хэмжээний дагуу зарцуулан жилийн эцсийн байдлаар 2500,0 сая төгрөгийн зардлыг зарцуулж 51,8 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан.

Дээрх батлагдсан 2551,8 сая төгрөгийн урсгал зардлыг төсвийн ангиллын дагуу зарцуулан хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцон өглөг авлага үүсгээгүй ба цалингийн санд батлагдсан орон тоогоор ажилласан.

2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой ажилчдын цалингийн тооцооллыг тухай бүр хийн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. 2024 оны төсвийн хуваарьт цалин хөлс, урамшуулал, тогтмол зардлууд, унаа хоолны нөхөн төлбөр өөрчлөгдөх, нийгмийн даатгалын Улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийн өөрчлөлтүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар төсвийн хуваарьт 7 удаа өөрчлөлт орсны үндсэн дээр тодотгосон.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 45,8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдэж тухайн хөрөнгө оруулалтыг дансанд бүртгэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан мэдээллийн санд бүрэн байршуулсан.

Дээрх хөрөнгө оруулалтын зардлаас 7,3 сая төгрөгийн зардлыг шууд худалдан авалтын гэрээ байгуулан ажил хүлээлцсэн гэрээ, дүгнэсэн актуудын дагуу тус газрын нэг давхрыг ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, өндөр настан иргэд, даатгуулагчдад зориулж тохижуулах ажлыг хийсэн.

Харин 38,5 сая төгрөгийн зардлыг тус газрын архивын үйлчилгээг сайжруулж иргэдэд түргэн шуурхай үзүүлэх, архивын цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж тендерт шалгарсан “Гарааны хас хос технологи” ХХК-тай гэрээ байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээн аван хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрэн барагдуулсан болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтийн горим баримтлан өр авлага үүсгэхгүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл:

Д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	1993.4	1949,2	44.2
2	НДШ	256.5	250.5	6.0
3	Тогтмол зардал	34.4	34.0	0.4
4	Бараа материал болон үйлчилгээний бусад зардал	99.2	98.0	1.2
5	Харуул хамгаалалт, зөвлөл хороодын зардал	103,7	103.7	0



6	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, бусад зардлууд	64.6	64.6	0
	ДҮН	2551.8	2500.0	51.8

Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгийн тооллогыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, элэгдлээ бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй тоног төхөөрөмж болон тавилга эд хогшлын 11,5 сая төгрөгийн жагсаалтыг гарган холбогдох хууль, дүрэм журмын дагуу акталсан. Үндсэн хөрөнгийн хагас жилийн болон жилийн эцсийн тооллого хийх, дүн мэдээг хүргүүлэх ажлыг газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/18 тоот тушаал, 2024 оны 10 дүгээр сарын 23-ны А/35 тоот тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулан тооллогыг хийж тайланг удирдлагад танилцуулж, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн 2024 оны мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн системд бүрэн шивж оруулсан.

Тооллогоор 516 ширхэг 1,688,562,263.94 төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолон баталгаажуулж ажилтан, албан хаагчдын картыг шинэчлэн кодлуулах ажлыг хийж дуусгасан. Актлах хөрөнгөд 57 ширхэг 1,154,200.00 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн.

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн дагуу Капитрон банкинд 38.5 мкв талбайг хагас жилийн хугацаатайгаар түрээслүүлэн гэрээг дүгнэсэн ба түрээслүүлэх байрны талбайг өөрчлөн 9,66 мкв талбайг түрээслүүлэх гэрээг үйлдэн Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт баталгаажуулахаар хүргүүлсэн.



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тус газрын “Төрийн өмчийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу шалгалтад хамрагдан үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалт 89 хувийн хангалттай үнэлгээгээр дүгнэгдсэн.

Хөрөнгийн тооллогын тоон баримт мэдээ тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.



Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн ил тод байдал

Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон 2024 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн тайлагнасан.

Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн хэрэгжилт нэвтрэлт 2024 оны 01 дүгээр сараас эхлэн шинэ системээр хөтөлсөн ба нэвтрэлтийн ажлын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын системийн хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын зохион байгуулж буй ZOOM уулзалтанд тухай бүр орж өгсөн чиглэл, даалгавар, зөвлөмжийн дагуу ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг шинэ системд бүртгэж ажиллаж байгаа бөгөөд бүрэн ашиглагдах хэмжээнд хүрээгүй байна.


2024 оны жилийн тайлангийн бэлтгэл ажлын хүрээнд шинэ системийн сургалт зөвлөгөө өгөх цахим багуудад хамрагдан бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэх Жира алдааны мэдээлэл авах системээр тухай бүр саналаа хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр






2021 оноос 2024 оны хооронд үүссэн Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага /Тэрбум/



ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ



Тус газарт иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг газрын дөрвөн хэлтэс болон тасгийн холбогдох ажилтан, албан хаагчдад хуваарилан түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд UB ERP программд бүртгэлтэй нийт 380 өргөдөл ирүүлснээс 376 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 4 өргөдлийг хариу өгөхөөр судалж, харин Able программаар нийт 847 албан бичиг хүлээн авч, 663 албан бичгийг бусад байгууллагад хүргүүлж, илгээж, программд холбогдоогүй төрийн байгууллагуудад /прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, цагдаагийн хэлтэс гэх мэт/ цаас болон шуудангаар хүргүүлэн ажилласан. Харин E-doc программд бүртгэлтэй 1056 албан бичгээс цаасан болон шуудан, программаар илгээж хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.

Мөн Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-д хандсан тус газартай холбоотой 100 гомдол, санал, хүсэлт ирснээс 99-ыг нь шийдвэрлэн, судлагдаж буй нэг хүсэлт байна.



Мөн тус газраас иргэн, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалтай холбогдох асуудлаар утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, утсаар гаргасан иргэдийн өргөдөл, гомдолд тухай бүр шуурхай хариу өгөхөөр ажиллаж байгаа бөгөөд “CallPro” холболтын тусламжтайгаар тухайн ажлыг зохион байгуулж байна.

Иргэд, даатгуулагч, ажил олгогчид утсаар мэдээлэл өгөхдөө тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, хувийн мэдээллийн нууцлалыг хангаж, шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг сайжруулах,




дуудлага алдалтыг багасгах, дуудлага хүлээн авч буй ажилтан, албан хаагчдийн үүргийг хариуцлагажуулах зорилгоор “Иргэд, даатгуулагч, ажил олгогчид утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх журам”-ыг боловсруулан газрын даргын 2024 оны А/36 дугаар тушаалаар батлан ажилтан, албан хаагчид дотооддоо мөрдлөг болгон ажиллаж эхэлснээр тухайн газрын “CallPro” үйлчилгээний дуудлага алдалтын үзүүлэлт эрс сайжраад байна.

**Цахим архивын үйл
ажиллагааны
талаар**

Тус газрын ажилтнууд 2024 онд хийх шинэлэг ажлын хүрээнд архиваа нэг стандарттай, цахим архивыг бий болгох зорилго тавин ажиллаж тэтгэврийн идэвхтэй хувийн хэргүүдийг бүрэн чипжүүлж дуусаад байна. Дүүргийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгуулсан “Цахим монгол-Цахим архив” төслийг бүрэн хэрэгжүүлж төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн, шуурхай хүргэх боломж нээгдэж, архивын хадгаламжийн нэгжийг цахимжуулж, чип суулгаж, хадгаламжийн нэгжийн болон тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хялбар хийж, бүртгэлжүүлж, мэдээлэл харах, хайж олох хялбар систем нэвтрүүлж, архивын мэдээллийг цахимжуулж дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Архивын хадгаламжийн нэгжүүдийг төрөлжүүлэн зөөж, өрөө тасалгаа, тавиур, тавцангуудыг нэмж суурилуулж, 1 өрөөг засварлан тохижилт хийж архивын өрөө болгож архивын өрөөнүүдийн гэрэлтүүлгийг бүрэн солиулсан.



- Архивын хадгаламжийн нэгжүүдийг төрөлжүүлсэн шинэ бүртгэлийн файл үүсгэсэн бөгөөд байнга-609, түр-4353, 70 жил-13336, тэтгэврийн идэвхтэй-23192 ш хувийн хэрэг, тэтгэврийн зогсоогдсон 15900 ширхэг хувийн хэрэг, хадгалах баримтуудыг “СБД-Цахим архив” програмж хангамжид бүртгэж, мэдээллийн сан үүсгэн бүрэн нэвтрүүлэн цэгцэлсэн.



- Идэвхтэй тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж хувийн хэргийн хавтас шинэчлэх, баяжуулалт хийх, дутуу хувийн хэргийг хайж олох зэрэг зэрэг хувийн хэргийн цэгцлэлт хийсэн.



- ISOO-2021 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд идэвхтэй 1324, зогсоогдсон 587 хайрцагт нийт 1911 хайрцгийг 3 төрлөөр ангилан өнгөт хавтас хийж нэгэн жигд хаягтай болгосон.





- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тус газрын архивыг цахимжуулах ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж тендерийн ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн идэвхтэй 23192 хувийн хэргийг чипжүүлж Үүлэн системд суурилсан Цахим архивын программ хангамжийг нэвтрүүлсэн. Цахим архивын программын бүртгэлийн файлыг 2 үндсэн 5 дэд системтэй зохиож мэдээллийн сан үүсгэж программ хангамжийг бүрэн нэвтрүүлсэн.





- Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд сүүлийн үеийн дэвшилтэт 2ш скайнер авч, дотоод нөөц болоцоогоо дайчлан нийт 23979 тэтгэврийн хувийн хэргийг скайнердаж цахим мэдээллин сан үүсгэхээр ажилласны үр дүнд 2024 онд 1-6 дугаар хорооны 6100 хувийн хэргийг бүрэн скайнердаж мэдээллийн сан үүсгэсэн.





НИЙТ АРХИВЫН ХАДГАЛАМЖИЙН НЭГЖИЙН ТООН СУДАЛГАА

№	Төрөл	Дэд төрөл	Дэд цэс	Чип тоо	Хайрцагны тоо
1	Тэтгэвэр	Идэвхтэй	ӨН	19929	1152
			ХЧТА	2416	118
			ТА	847	54
		Зогсоогдсон	ӨН	8424	344
			ХЧТА	4705	145
			ТА	2723	96
			ҮОМШӨ	21	1
Цэрэг	27	1			
ДҮН				39092	1911
2	Архив	Байнга	Байнга	609	
		Түр	Түр	4353	
		70 жил	НДШ төлөлт тайлан	10499	
			АЖТДШ нөхөн даатгал	577	
			Харилцах, бусад	2179	
			Нууц ЭЗИТБДТХ тайлан	81	
1990-1994 оны НДШ төлөлт					
ДҮН				18298	0
НИЙТ ДҮН				57390	1911

Тэтгэврийн хувийн хэргүүдийг скайнердаж мэдээллийн сан бүрдүүлэн цаасан баримтаас хайлт хийхгүй цахим архивын мэдээллийн сантай болох зорилго тавин ажилласны үр дүнд 1-6 дугаар хороонуудыг хувийн хэргүүдийг бүрэн скайнердсан.

Тус газарт нийт архивын байнга, түр, 70 жил хадгалах 18298 ширхэг хадгаламжийн нэгж, идэвхтэй 23192 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг, 1995 оноос хойших зогсоогдсон ба нас барсан тэтгэвэр авагчдын 15900 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

ТАВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ШАЛГАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах, дотоод хяналт шалгатаар:

Дотоод хяналт шалгалтаар:

Тайлант хугацаанд тус газрын захиргаа, хяналтын хэлтэс нь нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлсон байдал, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн ногдуулалт, төлөлт, тайланг хугацаанд нь тушааж буй байдлыг нийт 199 ажил олгогчийн 489 даатгуулагчийг хамруулан, Нийгмийн



даатгалын Улсын байцаагчийн актаар 97 ажил олгогчид 1,821,4 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 247,3 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 86,8 сая төгрөгийн алданги ногдуулж 334,1 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100 хувь барагдуулаад байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлдөггүй, тайланг хугацаандаа тайлагнаагүй даатгуулагчийн эрх ашгийг хохироосон нийт 46 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчдод Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.2, 10.17.4, 10.17.8, 10.17.9 дэх заалтын дагуу шийтгэврийн хуудсаар 44,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Дотоодын хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 2024 оны байдлаар шинээр тогтоогдсон 1178 өндөр насны тэтгэвэр авагчийн 1403,2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны 30 тэтгэвэр авагчийн 17,6 сая төгрөг, тахир дутуугийн 98 тэтгэвэр авагчийн 58,9 сая төгрөг нийт 1306 тэтгэвэр авагчийн 1 479,8 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Ажилласан жилийн нэмэгдэл 373 тэтгэвэр авагч хийлгэсэн мөн хөдөлмөрийн чадвар алдсан 250 тэтгэврийн сунгалт хийлгэсэн өөрчлөлтийг тухай бүр нь хянаж Sikos программд шийдвэрлэж ажилласан.

Мөн Хөдөлмөрийн чадвар түр алдалт 9,593 даатгуулагчийн 4,175,8 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсэн амаржсаны 2,038 даатгуулагчийн 7,625,9 сая төгрөгийн, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний хөдөлмөрийн чадвар түр алдалт 139 даатгуулагчийн 419,3 сая төгрөгийн нийт 11,770 даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг шалгаж 11,914,8 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав.

Тайлант хугацаанд 591 даатгуулагчдын 12,000,0 сая төгрөгийн нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн олголт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 2,039 хүнд олгосон 9,153,5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжид шалгаснаас ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаандаа ажил хийсэн, цалин буруу шивсэн, цалинг нэгдсэн мэдээллийн санд шивээгүй бодолт хийсэн, ажилласан жилийг нотлох баримт дутуу зэрэг зөрчлийг байсныг хариуцсан байцаагчаар тухай бүр нь засаж залруулав.

Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил 2024 оны байдлаар:

- Тэтгэмжийн даатгалын санд- 59 даатгуулагчийн 21,1 сая төгрөгийн төлбөрөөс 16,3 сая төгрөгийг төлүүлсэн.
- Тэтгэврийн даатгалын санд 2024 оны байдлаар шинээр 8 тэтгэвэр авагчтай холбоотой 245,6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 83,2 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж ажиллаа. Нийт 113 иргэнтэй холбоотой 542,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс дүнгээс 194,3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 348,0 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан.

Дээд газрын болон хөндлөнгийн хяналт шалгалтаар нийт 90 даатгуулагчтай холбоотой 50,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 40,7 сая төгрөгийг барагдуулж 9,5 сая төгрөгийг төлбөр зөрчлийг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнд:



- Тэтгэвэр 71 даатгуулагчийн 44,1 сая төгрөгийн төлбөрөөс 40,5 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж 5,1 сая төгрөг үлдсэн.
- Тэтгэмж 18 даатгуулагчтай холбоотой 1,5 сая төгрөгийн зөрчлөөс 200,6 мянган төгрөгийг барагдуулсан.
- Нийгмийн даатгалын сангийн 28 төрлийн мэдээлэл 160 удаа газрын үйл ажиллагааны 29 төрлийн 169 мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүрээр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж байна. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт тус тус цахимаар дараа сарын 8-ны дотор маягтын дагуу байршуулсан мэдээлэлд хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд тухайн хэлтэс нь тус газрын даргын баталсан удирдамжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн баталсан №01 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого, олголтыг тулган шалгах” ажлын удирдамжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны 23513 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн иж бүрэн байдал, тэтгэвэр олголт, тогтоолт, хөдөлгөөн бүрийг мэдээллийн бааз, хувийн хэрэгтээ тулган шалгалаа.

2. Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн баталсан №02 тоот “Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах ажлын удирдамж”-ын дагуу нийт ажил олгогчийн массив-10390, үйл ажиллагаа зогссон -3016, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан 7374 аж ахуй нэгж шалгасан.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03/26, 2/520 тоот “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлөөр 2021 оныг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон өндөр нас авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, тушаал, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр болон ажилласан жил нөхөн тооцуулахаар бүрдүүлсэн баримт анхан шатны баримт, цалингийн лавлагааны үндэслэл зэргийг архивын хянан шалгаж баталгаажуулах, илэрсэн дутагдлыг арилгаж ажиллаж байна. Шалгалтаар 1396 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шалгаж 53 тэтгэвэр авагчтай холбоотой 975,8 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 49 тэтгэвэр авагчийн 877,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг нотлон баталгаажуулж, 550,3 сая төгрөгийг төлүүлж үлдэгдэл 153,1 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцож барагдуулах ажил хийгдэж байна. Мөн 4 тэтгэвэр авагчийн 98,5 сая төгрөгийн төлбөр нотлогдоогүй, улсын байцаагчийн акттай 1 тэтгэвэр авагчийн 14,7 сая нийт 4 иргэний 113,2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц



хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 08/2075 албан бичгийн дагуу 62 аж ахуйн нэгж, байгууллагаас 44 байгууллага шалгаж 8 аж ахуй нэгж байгууллагад 44 даатгуулагчтай холбоотой Улсын байцаагчийн 8 актаар 109,602,054.85 төгрөгийн цалингийн сангаас 24,043,365.59 төгрөгийн шимтгэл 12,000,175.91 төгрөгийн алданги нийт акт, алданги 36,043,541.5 төгрөг 100% төлүүлсэн. Мөн зөрчилгүй 36 аж ахуй нэгжид улсын байцаагчийн зөвлөмж өгсөн. Зөрчлийн тухай хуулийн дагуу 8 аж ахуй нэгжийг 15,000,000.00 төгрөгөөр торгож торгуулийг бүрэн төлүүлсэн. Үйл ажиллагаа явуулахгүй тайлан өгөөгүй 7 байгууллага, захирал төлөөлөгч нь байхгүй 2 байгууллага, хойшлуулах хүсэлт өгсөн 3 байгууллага, аудит, шалгалт хийгдэж байгаа 2 байгууллага, Дипломат статустай, олон улсын гэрээтэй гэх 4 байгууллага нийт 18 байгууллага шалгуулаагүй байна.

5. Нүүрс тээврийн 12 байгууллагаас 4 байгууллага шалгаж 34 даатгуулагчтай холбоотой Улсын байцаагчийн 4 актаар 187,592,607 төгрөгийн цалингийн сангаас 50,226,771.75 төгрөгийн шимтгэл 25,113,385.88 төгрөгийн алданги нийт акт, алдангиар 75,340,157.63 төгрөг 100% төлүүлсэн. Харин нэг байгууллага Сонгино хайрхан дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй байх боловч нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт бүртгэлтэй нэг байгууллага, нэг байгууллага НДЕГ 2023 оныг дуустал шалгуулсан. Зөрчлийн тухай хуулийн дагуу 4 аж ахуй нэгжийг 8,000,000.00 төгрөгөөр торгож торгуулийг бүрэн төлүүлсэн. Таван аж ахуй нэгж баримт байхгүй гэсэн тайлбарыг өгч шалгуулаагүй.

6. Зөрчлийн тухай хуулийн 10.17.2, 10.17.4, 10.17.8, 10.17.9 дүгээр заалтын дагуу хялбаржуулсан журмаар 46 аж ахуй нэгж байгууллагад 44 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж Сүхбаатар дүүргийн Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан. Зөрчлийг хэрэг нээхээс татгалзсан тогтоол 18 байгууллагад гаргасан.

- 10.17.2-13 байгууллага-26,0 сая төгрөг
- 10.17.4-16 байгууллага-4,0 сая төгрөг
- 10.17.8-10 байгууллага- 10,0 сая төгрөг
- 10.17.9-8 байгууллага-4,0 сая төгрөг

нийт 16,5 сая төгрөгийн шийтгэлийн хуудсаар торгууль ногдуулсан.

- Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан тогтоол 18 байгууллагад улсын байцаагчийн актаар 11 даатгуулагчдад 197,8 сая төгрөгийн цалингын сангаас 19,2 сая төгрөгийн шимтгэлийг тооцож 9,4 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 28,7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг 100% барагдуулсан.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилтийг бүрэн хангаж, Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн хурлыг тайлант оны хугацаанд иргэдийг хуралд байлцуулахгүйгээр 100% бичиг баримтанд тулгуурлан нийт 46 удаа хуралдаж, 1912



иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна. Үүнээс 1355 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жагсаалтын шаардлагад нийцсэн 421 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовиур өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 133 иргэний хувь, хугацааг цуцлаад байна. Мөн 2024 онд зөвлөлийн харьяанд 41 иргэн шилжин ирж, 44 иргэн иргэний харьяаллын дагуу шилжсэн, 59 хүн нас барсан бүртгэлтэй байна. Шинээр хэрэгжиж эхэлсэн “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зөвлөлийн хурлыг зохион байгуулж буй ажлын явцыг Засгийн газрын хяналт үнэлгээний газарт танилцуулж, MNB, HDMонгол TV, TV-5 телевизийн сувгуудаар сурталчилж ажилласан.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэчилсэн дүрэм, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд баримтлах өвчний шинэчилсэн жагсаалтыг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт танилцуулах сургалтыг хийж, шинэчилсэн жагсаалтыг цаасаар болон цахимаар тарааж, мэдээллээр хангасан. Тайлант хугацаанд зөвлөл нийт 46 удаа, 184 цаг хуралдаж, гишүүдийн хурлын ирц дунджаар 90 хувьтай ажилласан.

Эрүүл мэндийн магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд улирал бүр хяналт хийж, даатгуулагчийн хувийн мэдээлэл зөрсөн байх магадлалтай, системийн шинэчлэл хийх бэлтгэл ажлын хүрээнд нас барсан хөдөлгөөн хийгээгүй, иргэний регистрийн дугаар, овог нэр алдаатай шивэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 124 хүний мэдээллийг нягтлан шалгах ажлыг хийж дуусгаад байна. Дүүргийн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн эхний хагас жилийн тоон тайланг гаргаж, хууль, дүрмэнд заасан хугацаанд багтаан Эрүүл мэндийн магадлах төв зөвлөлд цахимаар болон цаасаар хүргүүлээд байна. Тайлан оны хугацаанд дүүргийн хэмжээнд ердийн өвчин, ахуйн ослын шалтгаанаар 3097 хүн, үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар 33 иргэн, нийт 3130 хүн хөдөлмөрийн чадвар алдаж, 1140 хүн халамжийн сангаас, 1990 хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулинд орсон өөрчлөлтийн дагуу иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх хуралд иргэнийг заавал биечлэн байлцуулахгүйгээр шийдвэрлэж хэвшсэн. Тайлант хугацаанд зайлшгүй биечлэн үзлэг хийх 1 тохиодолд иргэнийг хуралд дуудан ирүүлж, шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна. Түүнчлэн шинээр батлан гаргасан иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх өвчний гарын авлагыг эмч нарт танилцуулж, тогтмол ашиглаж байгаа бөгөөд иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийг гаргахад оношийн баталгаажилтанд зөвхөн зайлшгүй шаардлагатай шинжилгээг шаардаж авсанаар иргэнээс илүү шинжилгээ хийлгэхгүй байх, явдал чирэгдэлгүй байхад анхаарч ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлтэй хамтарч ижил мэргэжилтний үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, дүүргийн Эрүүл мэндийн төвөөс нарийн мэргэжлийн 3 эмч, өрхийн 1 эмчийг оролцуулж, бусад 5 аймаг, дүүргийн ижил төстэй 10 картуудад шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргаж, танилцуулах ажлыг цахимаар хийж гүйцэтгэсэн. Ижил мэргэжилтний үнэлгээг зохион байгуулснаар эмч нар хоорондоо санал бодлоо

солилцох, маргаантай асуудлаар нэгдсэн нэг ойлголттой болох эерэг нөхцөл бүрдсэн нь сайн тал болсон.

Гишүүдийн хурлын ирцийн байдалд 7 хоног бүр тогтмол хяналт тавьж, хуралд оролцсон байдал, нарийн бичгийн даргын гаргасан цагийн тооцооны нэгтгэлийг сар бүр хянаж, зөвлөлийн дарга болон орлогч даргад танилцуулж баталгаажуулж хэвшээд байна.

Тайлант хугацаанд зөвлөл нийт 50 удаагийн хурлыг хийх ёстой байснаас 46 удаа, 348 цаг хуралдаж, гишүүдийн хурлын ирц дунджаар 90-ээс дээш хувь байна. Бүх нийтийн амралтын өдөр таарсан, 2023 оны жилийн тоон тайлан нэгтгэж дүүсаагүй зэрэг тус зөвлөлийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар 4 удаа зөвлөл хуралдаагүй болно.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Мэдээллийн технологийн ажлын хүрээнд

Даатгуулагчийн үндсэн мэдээлэл, төрөл, ажил мэргэжлийн ангилал, кодыг тухай бүр шалган, нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн нэвтрэлттэй холбоотой программ хангамжуудын эрхийн тохиргоог байцаагч, нэгж болгоноор үүсгэн шинэ системд ажиллах боломжийг бүрдүүлэн, программ хангамж ашиглалт, аюулгүй байдлыг хангаж байцаагч, нэгж болгонд нууц үг, нэвтрэх нэр үүсгэсэн.

Шинэ системийн сургалтад тухай бүр хамрагдан нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл технологийн ажилтнуудын цахим мэдээлэл солилцох хуудсаар бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд

Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан тус газарт бүртгэлтэй ажил олгогч, нягтлан бодогчдод дараах сургалт, мэдээллийг өгсөн.

- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга сэдвийн хүрээнд Орон сууц Нийтийн Аж ахуйн газар, ХҮТ-ийн ажилтан албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Сургалтаар Үйлчилгээний тасгийн дарга Ч.Эрдэнэчимэг Нийгмийн даатгалын хуулинд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэл өгч тэдний асуусан асуултад хариулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.



- Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн болон ХХҮХэлтсийн 1-20 дугаар хороодыг хариуцсан 50 ажилтан, албан хаагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хууль тогтоомжид орсон өөрчлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн талаарх (нэмэгдсэн болон нэршил өөрчлөгдсөн датгуулагчийн төрлийн код) мэдээллийг Гаалийн ерөнхий газрын хурлын танхимд зохион байгуулсан.



- Сургалтаар хамралт, орлогын тасгийн дарга, Нийгмийн даатгалын Улсын байцаагч Ё.Уранцэцэг "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, Сайн дурын даатгал", Магадлагч эмч, Нийгмийн даатгалын Улсын байцаагч Ж.Өнөгэрэл "Тэтгэмжийн асуудлаарх хуулийн өөрчлөлт, Цахим үйлчилгээ" сэдвийн хүрээнд мэдээлэл өгч ажиллаа.



Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан гамшгийн үед ажиллах Стратеги команд штабын дадлага сургуулилт зохион байгуулах шийдвэрийн дагуу Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, мэргэжлийн анги томилох тухай” А/37 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулан тус дадлага сургуулилтын хүрээнд Сүхбаатар дүүргийн нийгмийн



хамгааллын дүүргийн албаны төв штабт 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 11 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд амжилттай оролсон болно.



Тус газрын удирдах түвшний албан хаагчид манлайлал, ур чадварыг сайжруулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж байгаа бөгөөд Удирдлагын академийн ахлах түшмэлийн ангилалд газрын дарга Б.Энхтөр, төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Хамралт, орлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Солонго, Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дуламдорж нар 2 тус тус хамрагдан суралцаж байна.

- Fwd: Ахлах түшмэлийн сургалт 24А120 группэд суралцагчдын код бүхий мэдээлэл, EDU хаяг, EDU Хаягнаас TEAMS-д нэвтрэх заавар илгээж байна.

Yahoo/Inbox ☆

Enkhtur Badarch

From: b.enkhtur1980@gmail.com
To: uugii1005@yahoo.com

Wed, Dec 11 at 11:11 AM ☆

----- Forwarded message -----

From: **ТӨРИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ tas a** <tas.a@naog.gov.mn>
 Date: Thu, Nov 21, 2024, 17:06
 Subject: Ахлах түшмэлийн сургалт 24А120 группэд суралцагчдын код бүхий мэдээлэл, EDU хаяг, EDU Хаягнаас TEAMS-д нэвтрэх заавар илгээж байна.
 To: <aagii1005@yahoo.com>, <Amaraa2216@gmail.com>, <baasansurenbatmunkh888@gmail.com>, <Delger9381@gmail.com>, <munkhbat@ec.gov.mn>, <Munkhbayar1317@gmail.com>, <rentsenmyadag.d@med.gov.mn>, <soyolmaa@ec.gov.mn>, <tungalag@ec.gov.mn>, <bat.uugan7130@gmail.com>, <Tsekudjy@gmail.com>, <b.enkhtur1980@gmail.com>, <b.enkhtur1980@gmail.com>, <Amarsanaa919@gmail.com>, <Baatar4@gmail.com>, <bats41.8@gmail.com>, <magnai123@yahoo.com>, <Bilguun.d@mrpam.gov.mn>, <darjaa2020@gmail.com>, <delgerbat.d@gmail.com>, <demberelbold5@gmail.com>, <mungkhuu99@gmail.com>, <munkhuur@gmail.com>, <munkherdenebate@gmail.com>, <naransolongo@circ.gov.mn>, <narantsatsral.nad@gmail.com>, <turonon@gmail.com>, <oogino077@gmail.com>, <oyun@met.gov.mn>, <uizisaikhan.1933@gmail.com>, <tamiraabayar@gmail.com>, <undraa1921@gmail.com>, <khataa0606@gmail.com>, <kheegitseegee@gmail.com>, <tsagaanaaaa4@gmail.com>, <chinbat@met.gov.mn>, <n.chinzong1212@gmail.com>, <enkhtatbd@gmail.com>

БАТЛААХ Сургалтын багцын амжилтын газрын зарцаг

II ЭМЭГЭМЭГЭД

УМБРАЛААГИЙН АКАДЕМИ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АХЛАХ ТҮШМЭЛИЙН МЭРГЭШҮҮЛЭХ БАГЦ СУРГАЛТ

ТАХИМЭМЭ

ГРУПП 24А120, ТАХИМ 246 ТООТ

Огноо	I	II	III	IV	V	VI	VII	VIII
Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол
11.01.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.02.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.03.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.04.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.05.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.06.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.07.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.08.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.09.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.10.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.11.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11
11.12.24	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11	АТ11



Найм. Шинэлэг ажлын хүрээнд буюу дотоод ажлын чигэлээр

Тус газар нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж ажиллахаас гадна ажлын байрны эмх цэгц, иргэд даатгуулагчдад тав тух, таатай орчинг бүрдүүлэх, ажлын байрны стандартыг чанд баримтлан, үйлчилгээний чанар, хүртээмж ил тол байдлыг сайжруулж, шуурхай, илүү нээлттэй болгохыг эрхэм зорилго болгон дараах ажлуудыг санаачлан хийсэн.

1. Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 Олон Улсын стандартыг амжилттай нэвтрүүлж Сүхбаатар дүүрэгтээ энэхүү стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн хоёрдах төрийн байгууллага болж сертификатаа гардан авсан.



Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 Олон Улсын стандартыг нэвтрүүлсэн болон тус газры бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан коридорын давхрын хаягжилт, мэдээллийг бүрэн шинэчилж өөрчилсөн.




Бид даатгуулагчийнхаа итгэл ийгдвэр, сэтгэл ханамжаар үнэмсдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.





4 ДАВХАР	401	Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан
	401a	Газрын дарга
	402	Хурлын танхим
	403	Захиргаа, хяналтын хэлтсийн дарга
3 ДАВХАР	301	Захиргаа, хяналтын хэлтсийн мэргэжилтэнүүд
	301a	Хүний нөөцийн мэргэжилтэн
	302	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга
	303	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга
	304	Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч нар
305	Сургалтын өрөө	
2 ДАВХАР	201	Магадлагч эмч
	202	Тэтгэмжийн байцаагч нар
	203	Тэтгэврийн байцаагч нар
	204	Хамралт, орлогын хэлтсийн дарга Хамралт, орлогын хэлтсийн байцаагч нар
1 ДАВХАР	101	Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг Тасгийн дарга Байцаагч нар Банк
	102	Архивын ажилтнууд

7. Тус газраас нийгмийн даатгалын ач холбогдлыг иргэд, даатгуулагч, ажил олгогчдод таниулан сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын тооцоолуурыг санаачлан шинээр цахим системд бий болгосон. /<https://ndaatgal.vercel.app/> Тухайн тооцоолуур бий болсноор Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын фейсбүүк пэйж хуудсанд байршуулахад 134661 иргэд, даатгуулагчдад хүрснээс 11270 иргэд, даатгуулагч тус тооцоолуурыг ашиглан өөрийн тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцоолж үзсэн байна.





3. Нийгмийн даатгалын “Цахим хөтөч”-ийг тус газрын санаачилгаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэмжлэгтэйгээр AR технологи хөгжүүлэгч АРГУН компаниар хийлгэснээр нийгмийн даатгалын байгууллагуудаар үйлчлүүлж буй ажил олгогч, иргэд, даатгуулагчид “Цахим хөтөч”-өөс мэдээлэл авах боломжтой болсон.



4. Тус газрын санаачилгаар Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Даатгалтай иргэн” арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 11-15-ны хооронд 1-20-р хороонд зохион байгуулж хэлтсийн ажилтан, албан хаагч, улсын байцаагч нар батлагдсан хуваарийн дагуу хороодод ажиллаж нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулж тухайн ажлын хүрээнд сайн дурын даатгал болон албан журмын даатгалд нийт 182 даатгуулагч хамруулсан.

Handwritten signatures and official stamps for the 'Цахим хөтөч' project, including names like Нэг. Зоригийн, Хөвд. Зоригийн, Гурвал. Хамрах, Дарьд. Зоригийн, and Тав. Хэрхэл.

Table with 3 columns: 'Төлөөлөгч, танилчлагч', 'Ажил олгогчийг дэмжлэг бүртгэх', and 'Сайн дурын даатгалын үйлчилгээний үйлчилгээний байр'. It lists various roles and their responsibilities in the project.

Table titled '“ДААТГАЛТАЙ ИРГЭН” АЯНЫ ХҮРЭЭНД ХОРООДОД АЖИЛЛАХ ХУВААРЬ'. It contains columns for 'Д/р', 'Төлөөлөгч', 'Өдөр', 'Хороо', 'Цувр', and 'Хариуцаж буй албан хаагчид'. It lists the schedule for the project across different districts.


5. Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын нэг давхарт байрлах ариун цэврийн өрөөг тус газраас нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд, даатгуулагчид ашигладаг бөгөөд ихэвчлэн өндөр настан, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлдэг боловч зориулалтын бус тоноглолтойгоос дээрх иргэдэд үйлчлүүлэхэд хүндрэл үүсэх тохиолдол гардаг. Иймд тус газрын нэг давхрын ариун цэврийн өрөөг Сүхбаатар дүүргийн Тамгын газрын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилэх боломжийг бүрдүүлж тохижуулсан.



/засварын өмнө/



/засварын дараах/




5. Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчид Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан ногоон байгууламж нэмэгдүүлэн цэцэг тарих, орчны тохижилтод “Өнгө нэмье” аянд идэвх санаачлага гарган оролцож ажлын хэсэг байгуулан эрүүл таатай орчинд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Үүнд:

- Өрөө тасалгааны цэцгийн савыг Нийгмийн даатгалын байгууллагуудын ажлын байранд цэцэг байршуулах ISO-9001 стандартын дагуу цонх бүрт 2 ширхэгээр тооцон 190ш цэцгийн савыг ижилсүүлэн сольж бүх өрөөг цэцэгжүүлэв



6. Засвар хийхээс өмнө өрөө болон заал, коридорын хана тааз нь утааны бүсэд байдгаас шалтгаалан утаа тортог ихтэй, ханын хагалбар болон цууралтаар дулаан алдагдаж өвлийн улиралд ажилтан албан хаагчид дулаан хувцастай ажиллахаас аргагүй нөхцөлд ажиллаж байсныг иргэд даатгуулагч, ажилтан албан хаагчид тав тухтай орчинд ажиллаж үйлчилгээ авах боломжоор хангасан.


Засварын явц:



Засвар хийсний дараа



Үйлчилгээний 1 болон 2 давхрын заалны шалыг сольсон байдал:



Тус газрын конторын барилга нь өвлийн улиралд баригдсанаас шалтгаалан 2021 оноос барилгын дотор болон гадна талд суулт үүсэн хана тааз, гадна фасад, үүдний хэсэгт суулт өгсөн тул хөрөнгө оруулалтын санхүүжилт шийдвэрлүүлэх, тухайн барилгын их засварын зардлын төсөв, засварлах барилгын засварын батлагдсан зургийг гаргуулах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт явуулсны дагуу дүүргийн ЗДТГазраас 50,000,000,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн тендер зарлан тус газрын барилга байгууламжийн засварын ажлын зураг төсвийг “Хязгааргүй шулуун ХХК”-

иар хийж гүйцэтгүүлэн UNL2024/73 шифр бүхий зураг төслийг Барилгын хөгжлийн төвд баталгаажуулан хянуулахаар хүргүүлсэн.



Амралт, чөлөөт цаг

Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчид нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэхээс гадна нэгэн баг болж хамт олноороо чөлөөт цагийг хамтдаа өнгөрүүлэх байдлаар идэвхтэй оролцсон. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 82 жилийн ой, Нийгмийн хамгааллын ажилты өдрийг тохиолдуулан 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр “Эрүүл монгол хүн-Эко аяллын өдөрлөг” спорт, явган аялалд тус дүүргийн ажилтан, албан хаагчид хамт олноороо идэвхтэй оролцсон.



2. Тус газрын ажилтан албан хаагчид “Бид нэг салбарынхан” нэртэйгээр Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газрын ажлын туршлага, мэдээлэл солилцох зорилгоор “Ажлаа хийнгээ аялах” хөтөлбөр гарган ажилтан, албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх арга хэмжээг авч ажиллаа.



3. Тус газрын ажилтан, албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлж, амарч алжаал тайлах зорилго бүхий ажлын байранд **“Стрессгүй ажлын байр”** уриатайгаар амралтын өрөөг тохижуулсан. Тухайн өрөөг ажилтан, албан хаагчид амралтын өрөөг ашиглах заавар гарган, цагийн хуваариараар ашиглаж байна.

/Амралтын өрөөг тохижуулсан зураг/



Засварын дараа:



---o---

